



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг. 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

№ \_\_\_\_\_  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
П.ЛХАГВА-ОЧИР ТАНАА**

Төрийн аудитын газраас танай байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 87,960.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор бүрэн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ





БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2023 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [Erdeneb@audit.gov.mn](mailto:Erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Г.Цэрэнлхам  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Tserenlhamg@audit.gov.mn](mailto:Tserenlhamg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	10
3.4.2 Авлага .....	11
3.4.6 Үндсэн хөрөнгө .....	13
3.4.7 Өр төлбөр .....	14
3.4.10 Засгийн газрын хувь оролцоо .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.7.1 Завсрын аудитын талаар .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт .....	19
5.2 Албан шаардлага .....	19
5.3 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

Г ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
П.ЛХАГВА-ОЧИР ТАНАА

№ 303  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд бусдыгаа хошуучлан “Улсын тэргүүний сум шалгаруулах тухай” МУЗГ-ын 2022 оны 189 дугаар тогтоолоор улсын тэргүүний сумаар шалгарч гэрчилгээ, 100.0 (нэг зуун) сая төгрөгөөр шагнуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Шалгагдагч байгууллага нь Хутаг-Өндөр сумын өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй тул хариуцлага тооцох албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад тусгай сангийн дансны бичилтийг НББББ-ыг мөрдөөгүй, авлагыг хугацаагаар нь богино болон урт хугацаат

006020304

авлагаар ангилж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүйгээс бодитой мэдээллээр хэрэглэгчдийг хангаж чадахгүй эрсдэл үүсэж байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,458,297.40	678,914.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	570,889.20	259,168.90
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	427,559.40	274,297.40
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	-	2,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	459,848.90	143,348.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		12,177,443.80	6,728,979.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	12,177,443.80	6,728,979.40
39200	Биет хөрөнгө		11,921,019.70	6,640,785.50
39300	Биет бус хөрөнгө	13	256,424.10	88,193.90
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		13,635,741.20	7,407,893.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		16,408.10	55,756.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	16,408.10	55,756.30
41300	Өглөг	17а, 17б	16,408.10	55,756.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		13,619,333.10	7,352,137.60
51	Засгийн газрын хувь оролцоо		13,619,333.10	7,352,137.60
51100	Засгийн газрын оруулсан капитал		6,576,839.00	4,799,781.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		6,576,839.00	4,799,781.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		743,295.20	-
51200	Хуримтлагдсан үр дүн		2,756,639.70	1,757,619.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		3,542,559.20	794,736.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		13,635,741.20	7,407,893.80

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		8,705,001.90	4,744,506.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО		531,257.30	767,819.00
110	Орлогын албан татвар		103,931.30	429,604.70
1100	Хувь хүний орлогын албан татвар		103,931.30	429,604.70
113	Хөрөнгийн албан татвар		159,118.40	158,585.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж		268,207.50	179,628.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	2,766,921.80	962,119.20
120	Нийтлэг татварын бус орлого		2,766,921.80	962,119.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		5,406,822.80	3,014,567.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	7,002,266.70	4,236,495.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		7,002,266.70	4,236,495.50

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,922,387.00	2,359,892.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,723,680.80	475,510.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	358,395.10	59,249.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	618,533.10	636,254.20
2104	Хангамж, бараа материалын зардал	89,985.30	45,446.40
2105	Нормативт зардал	691,771.10	1,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,372.40	38,971.60
2107	Томилолт, зочны зардал	6,624.60	9,864.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	611,604.00	608,640.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	795,420.60	484,506.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,079,879.70	1,876,603.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,702,735.20	508,010.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	372,893.60	6,492,764.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,329,841.70	(5,984,754.30)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		6,901,416.70	4,571,777.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО		531,257.30	767,819.00
110	Орлогын албан татвар		103,931.30	429,604.70
1100	Хувь хүний орлогын албан татвар		103,931.30	429,604.70
113	Хөрөнгийн албан татвар		159,118.40	158,585.80
118	Бусад татвар, төлбөр, хураамж		268,207.50	179,628.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		99,384.20	35,623.70
1181	Газрын төлбөр		14,270.50	32,943.80
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		154,552.80	111,061.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		942,192.80	789,162.50
120	Нийтлэг татварын бус орлого		942,192.80	789,162.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		5,427,966.50	3,014,795.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		6,116,110.20	4,008,847.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ		6,116,110.20	4,008,847.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,964,809.00	2,115,464.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,898,859.30	654,556.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		413,266.50	111,024.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		616,927.70	789,970.40
2104	Хангамж, бараа материалын зардал		332,185.40	184,959.60

2105	Нормативт зардал	343,839.20	1,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,975.90	38,367.10
2107	Томилолт, зочны зардал	6,624.60	9,864.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,099.10	184,378.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	172,031.30	140,893.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,151,301.20	1,893,383.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	785,306.40	562,929.70
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	476,395.40	715,688.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	476,395.40	715,688.80
2200	Дотоод эх үүсвэрээр	476,395.40	715,688.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(476,395.40)	(715,688.80)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(14,748.10)	(158,961.10)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	14,748.10	158,961.10
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	294,162.90	(311,720.20)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	276,726.20	570,889.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	570,889.20	259,168.90

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,667,846.10	-	10,667,846.10
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	414,917.30	-	414,917.30
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,082,763.40	-	11,082,763.40
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	463,432.80	-	463,432.80
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	743,295.20	-	743,295.20
9	Тайлант үеийн үр дүн	1,329,841.70	-	1,329,841.70
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,619,333.10	-	13,619,333.10
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,619,333.10	-	13,619,333.10
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(281,778.70)	-	(281,778.70)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,337,554.30	-	13,337,554.30
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(662.50)	-	(662.50)
19	Тайлант үеийн үр дүн	(5,984,754.30)	-	(5,984,754.30)
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,352,137.60	-	7,352,137.60

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,616,169.10	2,205,638.24	410,530.86	84.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,594,758.60	1,497,862.94	96,895.66	93.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,553,936.50	1,457,090.92	96,845.58	93.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	484,168.20	472,933.75	11,234.45	97.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,008.30	59,058.45	1,949.85	96.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	650,432.20	635,468.73	14,963.47	97.70
2104	Хангамж, бараа материалын зардал	43,978.30	43,967.49	10.81	99.98
2105	Нормативт зардал	1,450.00	1,450.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,328.60	70,247.65	80.96	99.88
2107	Томилолт, зочны зардал	9,402.00	9,312.00	90.00	99.04
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,432.00	37,071.86	360.14	99.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	195,736.90	127,580.99	68,155.91	65.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,822.10	40,772.02	50.08	99.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,822.10	40,772.02	50.08	99.88
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	739,410.50	548,814.19	190,596.31	74.22
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	282,000.00	158,961.11	123,038.89	56.37
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,616,169.10	2,128,970.31	487,198.79	81.38
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,906,487.10	2,059,908.84	(153,421.74)	108.05
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	709,682.00	69,061.48	640,620.53	9.73
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	159	159	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	78	78	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	78	78	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	197,848.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	197,848.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	182,232.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,550.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	190.65
2104	Хангамж, бараа материалын зардал	1,899.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	195.00
2107	Томилолт, зочны зардал	552.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	161,796.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,048.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,615.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,937.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,678.93
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	193,281.71
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	193,281.71
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(4,566.66)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,566.66

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хутаг-Өндөр сум “Булган аймгийн Хутаг-Өндөр сум нь засаг захиргааны удирдлага, нийгмийн үйлчилгээг иж бүрнээр хүргэж, эрчимжсэн хөдөө аж ахуйтай, үйлдвэрлэл, үйлчилгээний бүсийн тулгуур төв болно” гэж алсын хараагаа тодорхойлсон байна.

Тайлант онд эрхэм зорилгоо “улс, аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан тойргийн сумдтай нээлттэй хамтран ажиллах замаар аймагтаа хүн амын хувьд ядууралгүй, эрүүл, боловсролтой, эдийн засгийн хувьд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлж, түүндээ түшиглэсэн жижиг дунд үйлдвэрлэл, дэд бүтэц бүрэн хөгжсөн тойргийн сумдад нийгмийн үйлчилгээг иж бүрэн үзүүлдэг бүсийн төв болно” гэж тодорхойлон ажилласан байна.

Дээрх зорилгынхоо хүрээнд “Монгол Улсын Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ард иргэдээ орон нутагтаа тав тухтай амьдрах, эрх чөлөө, эрдэм боловсролтой, урам зоригтой ажиллах нөхцөл бүрдсэн сум болгон хөгжүүлэхэд “Хүний төлөө” эдийн засгийг бий болгож, “Хөгжлийн төлөө Зөв бодлого” барьж ажиллан УЛСЫН ТЭРГҮҮНИЙ СУМ болоход оршино” хөгжлийн зорилтыг дэвшүүлэн, зорилтынхоо хэрэгжилтийг 100 хувь хангуулан “Улсын тэргүүний сум шалгаруулах тухай” МУЗГ-ын 2022 оны 189 дугаар тогтоолоор улсын тэргүүний сумаар шалгарсан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (4 удаа)
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолд оруулсан нэмэлт өөрчлөлт,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн хяналт аудитын алба 2022 онд Хутаг-Өндөр сумын Засаг даргын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын Засаг дарга нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 7,407.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,227.9 мянган төгрөгөөр буюу 45.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	570,889.2	259,168.9	(311,720.3)
Авлага	427,559.4	274,297.4	(153,262.0)
Урьдчилгаа	-	2,100.0	2,100.0
Бараа материал	459,848.9	143,348.1	(316,500.8)
Үндсэн хөрөнгө	12,177,443.8	6,728,979.4	(5,448,464.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>13,635,741.3</b>	<b>7,407,893.8</b>	<b>(6,227,847.5)</b>
Өр төлбөр	16,408.2	55,756.2	39,348.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	13,619,333.1	7,352,137.6	(6,267,195.5)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>13,635,741.3</b>	<b>7,407,893.8</b>	<b>(6,227,847.5)</b>

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс нөлөө бүхий буюу материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Материаллаг өөрчлөлт гарсан нь Монгол Улсын засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор сургуулийн өмнөх боловсролын өмнөх болон бага дунд боловсролын боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нь Боловсролын ерөнхий газрын дарга байхаар батлагдсан, Мөн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн "төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсноос нөлөөлсөн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагч аймгийн Засаг дарга байсныг Төсвийн тухай хуулийн 2022 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн өөрчлөлтөөр хүчингүй болгосонтой холбоотой байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 570,889.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 259,169.0 мянган төгрөг болж, 311,720.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	542,027.40	227,821.00	(314,206.40)	87.9
Арилжааны банк дахь харилцах	24,295.10	31,348.00	7,052.90	12.1
Нэмэлт санхүүжилтийн харилцах	4,566.70	-	(4,566.70)	-
<b>Дүн</b>	<b>570,889.20</b>	<b>259,169.00</b>	<b>(311,720.20)</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 40,288.4 мянган төгрөг буюу 15.5 хувийг Байгаль хамгаалах сан, 4,671.9 мянган төгрөг буюу 1.8 хувийг Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, 33,224.8 мянган төгрөг буюу 12.8 хувийг Хоршоо хөгжүүлэх сан, 549.1 мянган төгрөг буюу 0.2 хувийг Ерөнхий боловсролын сургууль, төгрөг 38,426.9 мянган буюу 14.8 хувийг Орон нутгийн ерөнхий орлого, 110,659.9 мянган төгрөг буюу 42.7 хувийг Орон нутгийн хөгжлийн сан эзэлж байна.

Арилжааны банк дахь харилцах дансанд Илчит хутаг ХХК-ий 31,348.0 мянган төгрөг байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос буурсан нь Байгаль хамгаалах сангийн үлдэгдэл аж ахуй нэгжүүд өөрсдөө нөхөн сэргээлт хийсэн, тайлант оны нөхөн сэргээлтийн төлөвлөсөн орлого тасарснаас, Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 1 зээлдэгчийн материал шаардлага хангаагүйд зээл олгоогүй, 9 зээлдэгч зээл олгосон, орон нутгийн ерөнхий орлогын дансанд өмнөх оны малын тоо толгойн албан татварын орлогыг ОНХС-ийн дансанд шилжүүлсэн, малын тоо толгойн албан татварын орлого жилийн эцэст тулж орсноос цаг хугацааны хувьд ОНХС-аар хийгдэх хөрөнгө оруулалт хийгдэх боломжгүй болж 2023 онд хийгдэхээр төлөвлөгдсөнөөс тус тус нөлөөлсөн байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны оны эхний үлдэгдэл 427,559.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 274,297.4 мянган төгрөг болж, 153,262.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3. Авлагын дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчтай холбогдсон авлага	15,786.00	9,270.40	(6,515.60)	3.4
Төлбөртэй үйлчилгээний авлага	237,630.80	4,995.00	(232,635.80)	1.8
Байгууллагаас авах авлага	183.5	7,931.80	7,748.30	2.9
Хувь хүмүүсээс авах авлага	173,959.10	252,100.20	78,141.10	91.9
<b>Дүн</b>	<b>427,559.40</b>	<b>274,297.40</b>	<b>(153,262.00)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 17,153.4 мянган төгрөг буюу 6.3 хувийг Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, 6,494.0 мянган төгрөг буюу 2.4 хувийг ЗДТГ, 4,995.0 мянган төгрөг буюу 1.8 хувийг Сум дундын ойн анги, 209,113.1 мянган төгрөг 77.0 хувийг Хоршоо хөгжүүлэх сан, 8,700.0 мянган төгрөг буюу 3.2 хувийг Улсын төсвийн хөрөнгө оруулалт, 12,209.4 мянган төгрөг буюу 4.5 хувийг Орон нутгийн ерөнхий орлого, 15,632.5 мянган төгрөг буюу 5.8 хувийг Илчит хутаг ХХК эзэлж байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Олон жил он дамжсан эзэн холбогдогч нь тодорхойгүй орон нутгийн ерөнхий орлогын 12,209.4 мянга, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 8,700.0 мянга төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

#### **3.4.3 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны оны эцэст 2,100.0 мянган төгрөг болж өмнөх оноос өссөн байна.

Хүснэгт №4. Урьдчилгааны дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Урьдчилж гарсан зардал	-	2,100.0	2,100.0	100.0
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>2,100.0</b>	<b>2,100.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд өмнөх оны аудитын төлбөрийн давхар шилжүүлэн үүссэн Илчит хутаг ХХК-ий авлага байна.

#### **3.4.4 Бараа материал**

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 459,849.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 143,348.1 мянган төгрөг болж, 311,042.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Бараа материал дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалттай материал	18,143.90	13,760.60	(4,383.30)	9.6
Эм боох материал	115,845.60		(115,845.60)	-
Бэлэн бүтээгдэхүүн	907.7	57.6	(850.10)	0.0
Бичиг хэргийн материал	7,567.40	50	(7,517.40)	0.0
Аж ахуйн материал	109,543.90	22,020.40	(87,523.50)	15.4
Түлш, шатах тослох материал	12,927.50	1,031.80	(11,895.70)	0.7
Барилгын засварын материал	6,087.10	5,965.00	(122.10)	4.2
Хүнсний материал	12,172.40		(12,172.40)	-

Бусад хангамжийн материал	175,578.20	100,462.70	(75,115.50)	70.1
Биологийн хөрөнгө	1,075.40		(1,075.40)	-
<b>Дүн</b>	<b>459,849.10</b>	<b>143,348.10</b>	<b>(311,042.30)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 107,707.8 мянган төгрөг буюу 75.2 хувийг ЗДТГ, 13,764.9 мянган төгрөг буюу 9.6 хувийг Сум дундын ойн анги, 21,875.3 мянган төгрөг буюу 15.2 хувийг Илчит хутаг ХХК эзэлж байна.

Засаг даргын тамгын газар бичиг хэргийн материал нөөцөлсөн, Сум дундын ойн анги Илчит хутаг ХХК өмнөх онд нөөцөлсөн нүүрс, шатах тослох материал, хангамжийн материал, сэлбэг хэрэгслийг тайлант онд зарцуулснаас бараа материал буурахад нөлөөлсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Илчит хутаг ХХК бараа материалын тооцоо бодсон акт байхгүй, бараа материалын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдэл тооллогын бүртгэлээс зөрүүтэй,
- Тайлант оны борлуулалтын өртгийг тооцохдоо үйлдвэрлэлд хамаарах цалингийн зардлыг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт тооцоогүй зөрчлүүд илэрсэн байна.

**3.4.6 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 12,177.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6,728.9 мянган төгрөг болж, 5,448.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга, байгууламж, орон сууц	16,045,994.60	7,327,204.60	(8,718,790.00)	108.89
Хуримтлагдсан элэгдэл	(6,053,341.50)	(1,854,624.20)	4,198,717.30	(27.56)
Авто-тээврийн хэрэгсэл	431,139.40	292,885.10	(138,254.30)	4.35
Хуримтлагдсан элэгдэл	(151,064.90)	(87,654.80)	63,410.10	(1.30)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,132,310.40	441,534.30	(690,776.10)	6.56
Хуримтлагдсан элэгдэл	(474,788.60)	(130,804.20)	343,984.40	(1.94)
Тавилга, аж ахуйн эд хогшил	350,770.60	83,973.20	(266,797.40)	1.25
Хуримтлагдсан элэгдэл	(163,083.30)	(43,107.90)	119,975.40	(0.64)
Зам, гүүрийн байгууламж	564,774.70	564,774.70	-	8.39
Хуримтлагдсан элэгдэл	(86,888.40)	(130,332.60)	(43,444.20)	(1.94)
Бусад үндсэн хөрөнгө	407,229.50	242,337.60	(164,891.90)	3.60
Хуримтлагдсан элэгдэл	(177,856.10)	(105,400.20)	72,455.90	(1.57)
Дуусаагүй барилга, байгууламж	2,390.00	-	(2,390.00)	-
Ном	93,433.40	40,000.00	(53,433.40)	0.59
Програм хангамж	9,500.00	5,540.00	(3,960.00)	0.08
Хуримтлагдсан элэгдэл	(1,456.30)	(1,022.50)	433.80	(0.02)
Бусад биет бус хөрөнгө	248,380.40	83,676.40	(164,704.00)	1.24
<b>Дүн</b>	<b>12,177,443.9</b>	<b>6,728,979.50</b>	<b>(5,448,464.40)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 2,831,965.9 мянган төгрөг буюу 41.7 хувийг ЗДТГ, 15,365.1 мянган төгрөг буюу 0.2 хувийг Сум дундын ойн анги, 3,792.223.2 мянган төгрөг буюу 56.7 хувийг Илчит хутаг ХХК эзэлж байна.

Сумын ОНХС-аас хийгдсэн хөрөнгө оруулалтыг сумын Засаг даргын 2022 оны А/472 дугаар захирамжаар Засаг даргын тамгын газарт 271,726.0 мянга, ИТХ-д 6,610.0 мянга, сум дундын Ойн ангид 77,515.0 мянга төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, эд хогшил, зам гүүрийн байгууламж, худаг зэрэг хөрөнгө оруулалтыг бүртгэлд тусгаснаас нэмэгдсэн, Илчит хутаг ХХК сумын ИТХ-ын 2022 оны 03/18 дугаар хуралдааны тогтоолоор 139,126.2 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг акталж данснаас хассанаас буурсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Үндсэн хөрөнгийн тайланд 39205, 39214, 39305, 39207, 39201 дансанд 32 нэр төрлийн ашиглалтын хугацааг хугацааг элэгдэл тооцох журмын дагуу тайлагнаагүй байна.
- Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын тайланд, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн материал үндсэн хөрөнгийн тайланд бүртгэлтэй байна. Мөн хөрөнгийг нэг бүрчлэн задалж бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэн байна.

**3.4.7 Өр төлбөр**

Өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 16,408.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 55,756.3 мянган төгрөг болж, 39,348.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	1,274.90	2,596.50	1,321.60	4.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	12,609.80	495	(12,114.80)	0.9
Байгууллагад төлөх өглөг	2,523.40	52,664.80	50,141.40	94.5
<b>Дүн</b>	<b>16,408.10</b>	<b>55,756.30</b>	<b>39,348.20</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 52,664.8 мянган төгрөг буюу 94.4 хувийг Илчит хутаг ХХК, 2,925.8 мянган төгрөг буюу 5.2 хувийг Засаг даргын тамгын газар, 165.7 мянган төгрөг буюу 0.4 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайланг тооцоо нийлсэн акт үйлдээгүй, 0-30 хоногийн хугацаа хэтэрсэн төлөлттэй байгаагаар тайлагнасан байна.

**3.4.10 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 13,619,333.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 7,355,137.6 мянган төгрөг болж, 6,267,195.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
----------	----------------	-----------------	------------------------	-----------------

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,576,839.00	4,799,781.00	(1,777,058.00)	65.3
Өмч /төрийн/ ТӨҮГ	743,295.20		(743,295.20)	-
Хуримтлагдсан үр дүн	2,756,639.70	1,757,619.70	(999,020.00)	23.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,542,559.20	794,736.90	(2,747,822.30)	10.8
<b>Дүн</b>	<b>13,619,333.10</b>	<b>7,352,137.60</b>	<b>(6,267,195.50)</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 1,750.0 мянган төгрөг буюу 0.1 хувь, 4,405,291.8 мянган төгрөг буюу 91.8 хувийг Илчит хутаг ХХК, 379,484.1 мянган төгрөг буюу 7.9 хувийг Засаг даргын тамгын газар, 13,225.0 мянган төгрөг буюу 0.2 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал эзэлж байна

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Орон нутгийн төсвийн орлогыг оны эхний үлдэгдлээс 60,000.0 мянга, татварын орлогоос 553,826.7 мянга, татварын бус орлогоос 94,648.0 мянган төгрөг нийт 708,474.7 мянган төгрөгөөр сумын ИТХ-д өргөн барьсан байна.

Өргөн барьсан төсвийг орон нутгийн төсвийн орлогыг 376,011.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, Сумын ИТХ-ын 2022 оны VI/09 хуралдаанаар урсгал орлогыг 1,084,486.3 мянга, хөрөнгийн орлогыг 303,716.7 мянга, санхүүгийн дэмжлэгийг 982,115.0 мянга, тусгай сангийн орлогыг 162,401.0 мянга, өмнөх оны эхний үлдэгдлээс 323,118.7 мянган төгрөг нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,855,904.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор 239,801.5 мянган төгрөгөөр бууруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 28 арга хэмжээг санхүүжүүлэхээр 926,774.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоос, 277,399.3 мянган төгрөгийг хөрөнгийн орлогоос, 721,962.9 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр 767,819.0 мянган төгрөгийн орон нутгийн төсвийн орлого, 277,399.3 мянган төгрөгийн хөрөнгийн орлого, 710,462.9 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, орон нутгийн төсвийн орлогыг 29,750.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,205,638.2 мянган төгрөг буюу 84.3 хувьтай байгаа Иргэдийн хурлын дарга 4,615.2 мянга, Засаг дарга 193,859.0 мянга, орон нутгийн өмчийн байр арчилгаа, хамгаалалт, засвар үйлчилгээний төлбөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 14,300.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 7. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

№	Хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Бие-лэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	119,941.1	115,325.9	4,615.2	96.2
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	983,194.9	789,335.9	193,859.0	80.3

3	Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалт	675,810.5	485,214.1	190,596.4	71.8
4	Ерөнхий боловсрол	529,000.5	526,536.4	2,464.1	99.5
5	Сургуулийн өмнөх боловсрол	111,166.7	99,885.3	11,281.4	89.9
6	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	82,019.2	81,464.1	555.1	99.3
7	Ойжуулалт	71,096.6	64,028.1	7,068.5	90.1
8	Соёл урлаг	43,939.6	43,898.1	41.5	99.9
Нийт дүн		2,616,169.1	2,205,687.9	410,481.2	84.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Аудитын илрүүлэлт:**

- Тооцоолсон цалингаар цалингийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардлаар НДШ, ХХОАТ, бусад өглөгийг бүртгэсэн.
- ЗДТГазар цалингийн зардлаас сумын ЗДТГ-ын даргын 2022 оны Б/12 дугаар тушаалаар нягтлан бодогч Ц.Булганчимэгт нэг сарын үндсэн цалингаар балансын урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.
- Иргэдийн төлөөлөгчдийн хурал нярвын тайланг гаргахдаа акруэл сууриар бүртгээгүй, он цагийн дарааллаар бус, бөөн дүнгээр 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр бүртгэж тайлагнасан байна. Мөн бэлтгэн нийлүүлэгчийн баримтыг үндэслэж орлогод авч зарцуулалт хийгээгүй байна.
- Илчит хутаг ХХК шатахууны зардлаас анхан шатны баримтгүй нийт 1,834.5 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан, шатахууны зардлаас анхан шатны баримтгүй нийт 1,834.5 мянган төгрөгийн шатахууныг тус тус зарцуулсан байна.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 197,848.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна. Нэмэлт орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 8. Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт (мянган төгрөг)

№	Эх үүсвэр, зориулалт	Мөнгөн дүн
1	Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас улсын тэргүүний сумын шагналд	100,000.0
2	Аймгийн ИТХ-аас сумын ИТХ-ын байгууллага дүгнэсэн шагнал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн зардалд	2,550.7
3	Эрүүл мэндийн төвийн өмнөх оны нэмэлт харилцахын үлдэгдэлд	4,561.3
4	Аймгийн Статистикийн хэлтсээс хөдөө аж ахуйн тооллогын зардал, багийн засаг дарга нарт сурталчилгааны зардалд, ХАА-н ээлжит тооллогын зардалд	5,324.6

5	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх зардалд, морин эргүүлийн урамшуулалд, отоглох цэг байгуулах зардалд, гамшгийн эрсдэлээс бууруулах зардалд, байгалийн гамшгийн эрсдэлээс бууруулах арга хэмжээний зардалд, цэвэр орчин цэмцгэр булган аяны зардалд, Ойн арчилгааны зардалд	40,260.4
6	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ЗДТГ-ын их засварын зураг төсвийн зардал, эрэн хайх аврах бүлгийн байрны засварын зардалд	36,896.2
7	Аймгийн Засаг даргын тамгын газраас аймгийн Засаг даргын А/57 дугаар захирамжаар хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 1-р байр эзэлсэн шагналд	4,385.0
8	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,871.0
Нийт дүн		197,848.4

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орон нутгийн төсвийн орлого, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/82 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь сумын ИТХ-ын хуралдаанаар батлагдсан нийт орлого ба тусламж санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт орлого ба тусламж санхүүжилт 2,616,169.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 39,242.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 29,431.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5-д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг сумын ИТХ, ЗДТГазар, Илчит хутаг ХХК, Сум дундын ойн анги гэсэн байгууллагууд нийт 4,721.5 мянган төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 154 мэдээлэл мэдээлэхээс сумын ИТХ, ЗДТГазар, Илчит хутаг ХХК, Сум дундын ойн анги гэсэн байгууллагууд нийт 4,721.5 мянган төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

##### **4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.7.1 Завсрын аудитын талаар**

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

##### **4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 1-2/276 дугаар албан тоотой ирүүлсэн.

*Хүснэгт 9. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	184,629.8	2	-	66.7
Зөвлөмж	2	-	2	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>184,629.8</b>	<b>4</b>	<b>-</b>	<b>80.0</b>

Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудлаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй хөрөнгөтэй тулгах, хөрөнгийн үлдэгдэлд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 87,960.2 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 87,960.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

#### 5.2 Албан шаардлага

1. Шалгагдагч байгууллага нь өмнөх оны Хутаг-Өндөр сумын ОНХС, СХС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 01/178, 01/179 дугаар албан шаардлагуудыг биелүүлээгүй, хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөж санхүүгийн тайлангаа бэлтгээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг биелүүлээгүй, алдаа зөрчлийг арилгаагүй, зөрчлийг дахин давтан гаргасан тул хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Орлогын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг 7,344.4 мянга, бууны албан татварын 678.0 мянга, малд ногдуулах орлогын албан татварыг 79,937.7 мянган төгрөг төсөвт төвлөрүүлэх ёстой нийт хөрөнгийн албан татварыг 87,960.2 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т "өөрийн өмчлөлд байгаа галт зэвсгийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлж албан татварыг тогтоосон хугацаанд төлөх, эвдэрч ашиглагдахгүй болсон галт зэвсгийг зохих журмын дагуу бүртгэлээс хасуулах", 7 зүйлийн 7.1 "Албан татвар төлөгч албан татварыг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор орон нутгийн төсөвт төлнө", Хутаг-Өндөр сумын ИТХ-н 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 08/05 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Хөрөнгийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд нөөц бололцоогоо дайчлан ажиллах.

#### 2. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Хутаг-Өндөр сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг байгууллагууд болон Сум дундын Ойн анги 4,721.5 мянган төгрөгийн 1 мэдээлэл мэдээлээгүй, ИТХурал 3 мэдээлэл, ЗДТГазар 2 мэдээлэл, Илчит хутаг ХХК-ий 15 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Өгсөн зөвлөмж:* Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	-											
ТӨҮГ	1	0.2			1	0.2	1	0.2				
ТШЗ	1	31.3			1	31.3	1	31.3				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>31.5</b>			<b>1</b>	<b>31.5</b>	<b>2</b>	<b>31.5</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	86.5	1	86.5			1	86.5	1	1		
ТӨҮГ	5	20.1	2	2.6	2	17.5	1	-				
ТШЗ	4	8.5	1	1.1	1	0.8	2	6.5				
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>115.1</b>	<b>4</b>	<b>90.2</b>	<b>3</b>	<b>18.3</b>	<b>3</b>	<b>6.5</b>	<b>1</b>	<b>1</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	1							
ТӨҮГ	1	4.7			1	4.7		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>4.7</b>			<b>2</b>	<b>4.7</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТТЗ	1	-					1	-
ТӨҮГ	2	0.5	1	0.5			1	-
ТШЗ	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>0.5</b>	<b>1</b>	<b>0.5</b>			<b>3</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>5.2</b>	<b>1</b>	<b>0.5</b>	<b>2</b>	<b>4.7</b>	<b>6</b>	<b>-</b>

